БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:БНА-2021/1/СТА-ТӨҮГ

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан 5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл 6
3.Аудитын тайлан 8
3.1. Ерөнхий зүйл 8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй 8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт 8
3.4. Материаллаг байдал 9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд 9
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга 10
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа 11
3.8. Шилэн дансны мэдээлэл 11
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 11
3.10. Аудитын илрүүлэлт 12
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд 12
4. Менежментийн захидал 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт 15

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН ДАРГА Ж.ГАНХҮЛЭГ ТАНАА

2021.03.15 № 2/178

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	5,312,512.16	38,693,026.79
1.1.2	Дансны авлага	4,374,710.90	4,420,796.20
1.1.4	Бусад авлага	3,046,621.02	2,926,621.02
1.1.6	Бараа материал	91,391,150.85	61,209,245.04
	Эргэлтийн хөрөнгийн дүн	**104,124,994.93**	**107,249,689.05**
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,088,647,758.32	987,217,891.13
1.2.2	Биет бус хөрөнгө	1,030,960,000.00	1,034,524,659.84
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**2,119,607,758.32**	**2,021,742,550.97**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**2,223,732,753.25**	**2,128,992,240.02**
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0	50,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0	300,000.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	**0**	**350,000.00**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**0**	**350,000.00**
2.3	**Эздийн өмч**	**1,519,736,486.75**	**1,519,736,486.75**
2.3.1	Өмч: - төрийн	1,030,960,000.00	1,030,960,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	488,776,486.75	488,776,486.75
2.3.9	Хуримтлагдсан ашиг	703,996,266.50	608,905,753.27
	Эздийн өмчийн дүн	**2,223,732,753.25**	**2,128,642,240.02**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**2,223,732,753.25**	**2,128,992,240.02**

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	11,356,067.59	7,614,324.00
2	Борлуулалтын өртөг	926,499,819.85	1,068,498,554.96
3	**Нийт ашиг (алдагдал)**	**-915,143,752.26**	**-1,060,884,230.96**
5	Хүүний орлого	1,057,947.71	293,306.70
8	Бусад орлого	851,382,485.10	1,011,124,007.70
9	Борлуулалт маркетингийн зардал	0	0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,840,880.00	1,723,800.00
11	Санхүүгийн зардал	0	0
12	Бусад зардал	55,605,087.30	43,899,796.67
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**	**- 120,149,286.75**	**-95,090,513.23**
19	Орлогын татварын зардал	0	0
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**- 120,149,286.75**	**-95,090,513.23**
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**- 120,149,286.75**	**-95,090,513.23**
28	**Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)**	**- 120,149,286.75**	**-95,090,513.23**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл**	**1,519,736,486.75**	**824,145,553.24**	**2,343,882,039.99**
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	-120,149,286.74	-120,149,286.74
9	**2019 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл**	**1,519,736,486.75**	**703,996,266.50**	**2,223,732,753.25**
11	**Залруулсан үлдэгдэл**	**1,519,736,486.75**	**703,996,266.50**	**2,223,732,753.25**
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	-95,090,513.23	-95,090,513.23
17	**2020 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл**	**1,519,736,486.75**	**608,905,753.27**	**2,128,642,240.02**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**794,515,976.96**	**892,442,723.90**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,991,544.70	8,225,905.90
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	780,100,000.00	883,716,000.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	6,424,432.26	500,818.00
1.1.6.1	Банк хоорондын гүйлгээ	13,891,500.00	18,412,500.00
1.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**789,915,904.07**	**859,355,515.97**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	402,846,093.69	447,544,601.83
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	64,756,750.11	127,850,737.70
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	89,709,931.65	84,662,270.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	25,430,632.02	83,282,106.24
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	28,086,000.00	35,497,509.20
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	51,874,366.25	54,975,336.70
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	61,513,881.70	4,842,500.00
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	65,698,248.65	20,700,454.30
1.2.9.1	Банк хоорондын гүйлгээ	9,564,847.73	18,412,500.00
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**4,600,072.89**	**33,087,207.93**
2.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**0**	**293,306.70**
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0	293,306.70
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**0**	**293,306.70**
4	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**4,600,072.89**	**33,380,514.63**
4	**Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ**	**4,600,072.89**	**33,380,514.63**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**712,439.27**	**5,312,512.16**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**5,312,512.16**	**38,693,026.79**

2.5 Аудит хийсэн орлого, зарлагын төлөвлөгөө гүйцэтгэл

/төгрөг/

	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	УРСГАЛ ЗАРДАЛ	796,834,700.00	1,030,194,400.00	859,355,515.97	170,838,884.03	83.42
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	761,249,900.00	1,001,859,300.00	859,355,515.97	142,503,784.03	85.78
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	486,014,500.00	597,506,200.00	525,103,565.72	72,402,634.28	87.88
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	431,964,500.00	516,431,200.00	447,838,565.72	68,592,634.28	86.72
2	Унаа хоолны хөнгөлөлт	54,050,000.00	81,075,000.00	77,265,000.00	3,810,000.00	95.30
2102	Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,422,700.00	80,663,400.00	69,269,669.94	11,393,730.06	85.87
1	Тэтгэврийн даатгал	41,858,000.00	50,788,000.00	69,269,669.94	(18,481,669.94)	136.39
2	Тэтгэмжийн даатгал	4,924,500.00	5,975,100.00		5,975,100.00	-
3	ҮОМШ-ийн даатгал	8,864,000.00	5,975,100.00		5,975,100.00	-
4	Ажилгүйдлийн даатгал	1,015,600.00	5,975,100.00		5,975,100.00	-
5	Эрүүл мэндийн даатгал	9,760,600.00	11,950,100.00		11,950,100.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,876,500.00	53,372,500.00	51,300,377.00	2,072,123.00	96.12
1	Гэрэл, цахилгаан	23,414,000.00	28,826,200.00	22,309,997.00	6,516,203.00	77.39
2	Түлш, халаалт	18,462,500.00	24,546,300.00	28,990,380.00	(4,444,080.00)	118.10
2104	Хангамж, бараа материалын зардал	67,162,600.00	71,109,200.00	70,702,535.94	406,664.06	99.43
1	Бичиг хэрэг	5,189,400.00	5,767,000.00	4,119,740.00	1,647,260.00	71.44
2	Тээвэр, шатахуун	50,252,600.00	53,190,200.00	53,178,009.20	12,190.80	99.98
3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,535,300.00	6,801,300.00	8,956,986.74	(2,155,686.74)	131.70
4	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,683,700.00	3,041,900.00	2,767,900.00	274,000.00	90.99
5	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,501,600.00	2,308,800.00	1,679,900.00	628,900.00	72.76
2105	Норматив зардал	3,825,000.00	7,260,000.00	7,260,000.00	-	100.00
1	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,825,000.00	7,260,000.00	7,260,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,300,600.00	84,446,100.00	87,441,832.00	(2,995,732.00)	103.55
1	Багаж, техник, хэрэгсэл	59,840,000.00	75,896,500.00	79,658,852.00	(3,762,352.00)	104.96
1.1	Барилга	24,371,000.00	40,000,000.00	48,138,700.00	(8,138,700.00)	120.35
1.2	Тоног төхөөрөмжийн	12,359,400.00	10,445,700.00	17,518,402.00	(7,072,702.00)	167.71
1.2	Автомашин	8,315,900.00	8,959,800.00	1,691,500.00	7,268,300.00	18.88
1.4	Аэродром	10,248,300.00	10,251,000.00	8,582,250.00	1,668,750.00	83.72
1.5	Гал унтраах зардал	4,545,400.00	6,240,000.00	3,728,000.00	2,512,000.00	59.74
2	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,460,600.00	8,549,600.00	7,782,980.00	766,620.00	91.03

ҮЗҮҮЛЭЛТ		2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2107	Томилолт, зочны зардал	22,736,500.00	23,000,000.00	21,736,500.00	1,263,500.00	94.51
1	Дотоод албан томилолт	22,736,500.00	23,000,000.00	21,736,500.00	1,263,500.00	94.51
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,211,500.00	36,976,900.00	14,282,306.00	22,694,594.00	38.62
1	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,960,900.00	2,450,000.00	2,383,000.00	67,000.00	97.27
2	Даатгалын үйлчилгээ	4,298,000.00	4,842,500.00	4,842,500.00	-	100.00
3	Тээврийн хэрэгслийн татвар	340,100.00	385,800.00	932,376.00	(546,576.00)	241.67
4	Газрын төлбөр	2,474,000.00	29,148,600.00	5,969,000.00	23,179,600.00	20.48
5	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	138,500.00	150,000.00	155,430.00	(5,430.00)	103.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	47,525,000.00	292,430.67	47,232,569.33	0.62
1	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	2,000,000.00	292,430.67	1,707,569.33	14.62
Түүхий эд материал		-	45,525,000.00		45,525,000.00	-
Харуул, хамгаалалтын зардал		186,800.00	900,000.00	154,500.00	745,500.00	17.17
Ул хөдлөх хөрөнгийн татвар		8,185,000.00	16,370,100.00	7,946,798.70	8,423,301.30	48.54
Биеийн тамирын уралдаан, тэмцээн		500,000.00	500,000.00		500,000.00	-
Шүүхийн шийдвэрийн дагуу олгох төлбөр		19,799,000.00	-		-	
Сургалт семинар		1,000,000.00	2,000,000.00	50,000.00	1,950,000.00	2.50
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг		6,135,000.00	7,300,000.00	2,550,000.00	4,750,000.00	34.93
	Нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг	3,800,000.00	4,500,000.00	2,550,000.00	1,950,000.00	56.67
	Шагнал урамшуулал, баяр ёслол	2,335,000.00	2,800,000.00		2,800,000.00	-
Эмчилгээний төлбөр		575,000.00	1,265,000.00	1,265,000.00	-	100.00
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	13,527,100.00	18,573,200.00	9,020,030.60	9,553,169.40	48.56
	Бүүлт, хөөрөлтийн орлого	4,339,300.00	5,173,200.00	7,598,565.90	(2,425,365.90)	146.88
	Зорчигч үйлчилгээний орлого	730,800.00	1,400,000.00	627,340.00	772,660.00	44.81
	Бусад орлого	8,457,000.00	12,000,000.00	794,124.70	11,205,875.30	6.62

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг дарга Ж.Ганхүлэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төрийн өмч, хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь байршуулж байх талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 08-аас 2021 оны 03 дугаар сарын 15–ний хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2020 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 161 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Баянхонгор аймаг дахь салбар гэсэн статустай байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын улсын бүртгэлийн гэрчилгээнд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэний нисэхийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж эрх зүйн орчин бүрдүүлэх, иргэний нисэхийн болон аюулгүй байдлыг хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудалсанхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын албанаас 2021 оны 08 дугаар сард дотоод аудит, хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудит, хяналт шалгалтаар нийт 13 заалт бүхий алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн ба 2020 оны 08 дугаар сарын 30-нд "Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг залруулах ажлын төлөвлөгөө"-г газрын даргаар батлуулан төлөвлөгөөний биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2020 оны 09 дүгээр сарын 30-нд Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлсэн байна.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 983945.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 19678.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1114122.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 22282.4 мянган төгрөгөөр тооцов.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2129.0 сая төгрөг болж өмнөх оноос 94.7 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	104,125.0	107,249.7	3,124.7
Мөнгөн хөрөнгө	5,312.5	38,693.0	33,380.5
Авлага	7,421.3	7,347.4	(73.9)
Урьдчилгаа			-
Бараа материал	91,391.2	61,209.2	(30,181.9)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,119,607.8	2,021,742.6	(97,865.2)
Үндсэн хөрөнгө	6,902,826.3	6,938,236.47	35,410.2
Хуримтлагдсан элэгдэл	4,783,218.5	4,916,493.9	133,275.4
Нийт хөрөнгө	2,223,732.8	2,128,992.2	(94,740.5)
Өр төлбөр		350.0	350.0
Эздийн өмч	2,223,732.8	2,128,642.2	(95,090.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,223,732.8	2,128,992.2	(94,740.5)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 38.7 сая төгрөг болж 33.4 сая төгрөгөөр өссөн нь Иргэний нисэхийн ерөнхий газраас олгосон санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг арилжааны банкин дахь харилцах дансанд үлдэгдлээр байршуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 7.4 сая төгрөг болж 0.1 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлагаас 0.1 сая төгрөг тайлант онд төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2017 онд үүссэн, он удаан жил болсон 2.9 сая төгрөгийн хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 61.2 сая төгрөг болж 30.2 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээр байсан 27.0 сая төгрөгийн материалыг тайлант онд зарцуулж 3.2 сая төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

Тайлант онд худалдан авалтаар 218.2 сая төгрөг, Иргэний нисэхийн ерөнхий газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 66.0 сая төгрөгийн нийт 218.2 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6938.2 сая төгрөг болж 35.4 сая төгрөгөөр өссөн нь , Иргэний нисэхийн ерөнхий газраас 55.6 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 111 дүгээр тогтоолын дагуу 20.2 сая төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.4 сая төгрөг болж 0.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ажиллагсадтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн 0.1 сая, шагнал урамшууллын 0.3 сая төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 2128.6 сая төгрөг болж 95.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны хуримтлан үр дүн 95.1 сая төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 488.8 сая төгрөг байгаа ба тайлант онд өөрчлөлт гараагүй болно

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2020 оны орлого, зарлагын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 18.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 1030.2 сая төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 7.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 859.4 сая төгрөгийн зардал гарган, Иргэний нисэхийн ерөнхий газраас 883.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Орлогын эх үүсвэр нь буулт хөөрөлтийн орлого, зорчигч үйлчилгээний орлого бүрджээ.

Нийт орлогын гүйцэтгэл 7.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 9.6 сая төгрөг буюу 42.6 хувиар тасарсан нь буулт хөөрөлтийн орлого 2.4 сая төгрөгөөр давж биелсэн ч зорчигч үйлчилгээний орлого 0.8 сая, бусад орлого 11.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс дутуу биелсэн нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 859.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 170.9 сая төгрөг буюу 83.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайланд онд төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой гол нөлөө үзүүлсэн байна.

Тус байгууллагын орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ		2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
УРСГАЛ ЗАРДАЛ		796,834,700.00	1,030,194,400.00	859,355,515.97	170,838,884.03	83.42
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		761,249,900.00	1,001,859,300.00	859,355,515.97	142,503,784.03	85.78
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	486,014,500.00	597,506,200.00	525,103,565.72	72,402,634.28	87.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,422,700.00	80,663,400.00	69,269,669.94	11,393,730.06	85.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,876,500.00	53,372,500.00	51,300,377.00	2,072,123.00	96.12
2104	Хангамж, бараа материалын зардал	67,162,600.00	71,109,200.00	70,702,535.94	406,664.06	99.43
2105	Норматив зардал	3,825,000.00	7,260,000.00	7,260,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,300,600.00	84,446,100.00	87,441,832.00	(2,995,732.00)	103.55
2107	Томилолт, зочны зардал	22,736,500.00	23,000,000.00	21,736,500.00	1,263,500.00	94.51
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,211,500.00	36,976,900.00	14,282,306.00	22,694,594.00	38.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	47,525,000.00	292,430.67	47,232,569.33	0.62
Түүхий эд материал		-	45,525,000.00		45,525,000.00	-
Харуул, хамгаалалтын зардал		186,800.00	900,000.00	154,500.00	745,500.00	17.17
Үл хөдлөх хөрөнгийн татвар		8,185,000.00	16,370,100.00	7,946,798.70	8,423,301.30	48.54
Биеийн тамирын уралдаан, тэмцээн		500,000.00	500,000.00		500,000.00	-
Шүүхийн шийдвэрийн дагуу олгох төлбөр		19,799,000.00	-		-	
Сургалт семинар		1,000,000.00	2,000,000.00	50,000.00	1,950,000.00	2.50
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг		6,135,000.00	7,300,000.00	2,550,000.00	4,750,000.00	34.93
Эмчилгээний төлбөр		575,000.00	1,265,000.00	1,265,000.00	-	100.00
НИЙТ ОРЛОГЫН ДҮН		13,527,100.00	18,573,200.00	7,907,630.70	9,553,169.40	42.58
Бүулт, хөөрөлтийн орлого		4,339,300.00	5,173,200.00	7,598,565.90	(2,425,365.90)	146.88
Зорчигч үйлчилгээний орлого		730,800.00	1,400,000.00	627,340.00	772,660.00	44.81
Бусад орлого		8,457,000.00	12,000,000.00	794,124.70	11,205,875.30	6.62

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь Иргэний нисэхийн ерөнхий газрын шууд харьяанд үйл ажиллагаа явуулж байгаа ба тус байгууллагад төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээлэл оруулахаас бүтэн жилээр оруулах Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын 1, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл холбоотой 1 нийт 77736.6 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 3. Шилэн дансны мэдээлэл оруулсан байдал

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	9	9	9		2
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	33	3	
5	Тухай бүр	8	96	92	4	
	Нийт	24	148	141	7	2

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт сая.төг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	331.2	1	331.2	100
Албан шаардлага	1	18531.0	1	18531.0	100
Зөвлөмж	2	3046.6	1	120.0	3.9
Нийт дүн	4	21908.8	3	18982.2	86.6

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 25.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 25.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Төлбөрийн акт, албан шаардлага

1. Тайлант онд уурын зуухны халаалтын тогоог засварлан шинэ халаалтын тогоо суурилуулсан боловч хуучин ашиглаж байсан 2011 онд бүртгэсэн 21081656 төгрөгийн үнэ бүхий халаалтын тогоог акталж данснаас хасах шийдвэр гараагүй боловч аудитын явцад газар дээр нь очиж шалгахад хөрөнгө биетээр байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;" 14.4 дэх "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах." гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3-т заасны дагуу тус акталж данснаас хасах шийдвэр гараагүй байхад дутсан хөрөнгөтэй холбоотой асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх албан шаардлага өгөх.

2. Тус байгууллагын даргаар ажиллаж байсан Н.Баярхүүгийн 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн Б/35 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн жолооч Б.Хүрэлбаатарт Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 131/ШШ2019/00935 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлд 1121211.28 төгрөгийг Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын төсвөөс олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн, "Эрх ба үүрэг", гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь заалтын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын албанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3. Тус байгууллагын авлагын дансны үлдэгдэл 7347.4 мянган төгрөг байгаа ба үүнээс 4420.8 мянган төгрөг нь тайлант онд үүссэн бол 2926.6 мянган төгрөг нь 2017 онд үүссэн ажиллагсадтай холбоотой авлагын үлдэгдэл ба өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулж авлагыг барагдуулах зөвлөмж өгсөн ч хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онуудад үүссэн олон жилийн насжилттай 2926.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх албан шаардлага өгөх.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

1. Тус байгууллагын даргаар ажиллаж байсан Н.Баярхүүгийн 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн Б/35 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн жолооч Б.Хүрэлбаатарт

Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 131/ШШ2019/00935 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлд 1121211.28 төгрөгийг 2020 онд Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын төсвөөс олгосон байна. Энэхүү зөрчил нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх заалтыг зөрчсөн тул Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь заалтыг үндэслэн Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын албанд албан шаардлага хүргүүлсэн тул хэрэгжилтийн талаар арга хэмжээ авсан эсэхийг тодруулж үзэх.

2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 18/16 дугаар тогтоолоор "Баянхонгор аймгийн агаарын тээврийн нислэгийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх" төсөл, арга хэмжээнд орон нутгийн ангилагдаагүй зардлаас 70.0 сая төгрөг баталж өгсөн байна.

Тус арга хэмжээг орон нутгаас хэрэгжүүлэхдээ "Баянхонгор аймгийн Нисэх буудлын оффисын барилгын гадна засварын ажил" нэрээр худалдан авах ажиллагаа зохион байгуулан 2020.08.31-нд "Жаргантайн хөх тариа" ХХК-тай 116.5 сая төгрөгөөр гэрээ байгуулан хэрэгжүүлсэн ба засварын ажил дуусаагүй 2021 онд үргэлжлэн хийгдэхээр байна. Худалдан авах ажиллагааг орон нутгаас зохион байгуулан гэрээг аймгийн Засаг дарга байгуулж санхүүжилтийг орон нутгийн төсвөөс гүйцэтгэгчид олгосон байна.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан зориулалтын дагуу хэрэгжүүлсэн эсэхийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хийх гүйцэтгэлийн аудитаар авч үзэх шаардлагатай.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээлэл оруулахаас бүтэн жилээр оруулах Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын 1, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл холбоотой 1 нийт 77736.6 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсний дагуу төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл холбоотой мэдээллийг хугацаанд нь байршуулж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой данстай холбоотой асуудал

2.1. *Илрүүлэлт:* Аудитын явцад 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар ТС-1 шатахууны үлдэгдлийг газар дээр нь очиж хэмжиж баталгаажуулахад 71.3 кг-ийн илүүдэлтэй байна .

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.2. Эрсдэл: Эд хөрөнгийн тооллого тооцоог хийж үр дүнг шийдвэрлээгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж: ТС-1 шатахууны тооллогыг тогтмол хийж үр дүнг тооцон нягтлан бодох бүртгэлд тусгаж баталгаажуулж байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР Ж.ӨСӨХБАЯР 2021.03.15

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.03.15

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.03.15

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:		Аудитын код:
2020		*Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит*	САГ-2021/../СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:		*Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудал*	мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуулагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд уурын зуухны халаалтын тогоог засварлан шинэ халаалтын тогоо суурилуулсан боловч хуучин ашиглаж байсан 2011 онд бүртгэсэн 21081656 төгрөгийн үнэ бүхий халаалтын тогоог акталж данснаас хасах шийдвэр гараагүй боловч хөрөнгө биетээр байхгүй байна.	21,081.7	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Ж.Ганхүлэг, Д.Одончимэг
2	Тус байгууллагын даргаар ажиллаж байсан Н.Баярхүүгийн 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн Б/35 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн жолооч Б.Хүрэлбаатарт Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 131/ШШ2019/00935 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлд 1121211.28 төгрөгийг Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын төсвөөс олгосон байна.	1,121.2	Албан шаардлага өгөх	Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын албаны дарга	Н.Мөнхсүрэн
3	Тус байгууллагын авлагын дансны үлдэгдэл 7347417 төгрөг байгаа ба үүнээс 4420796 төгрөг нь тайлант онд үүссэн бол 2926621 төгрөг нь 2017 онд үүссэн ажиллагсадтай холбоотой авлагын үлдэгдэл ба өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулж авлагыг барагдуулах зөвлөмж өгсөн ч хэрэгжүүлээгүй байна.	2,926.6	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Ж.Ганхүлэг, Д.Одончимэг
4	Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээлэл оруулахаас бүтэн жилээр оруулах Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын 1, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл холбоотой 1 нийт 77736.6 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ж.Ганхүлэг, Д.Одончимэг
5	Аудитын явцад 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар ТС-1 шатахууны үлдэгдлийг газар дээр нь очиж хэмжиж баталгаажуулахад 71.3 кг-ийн илүүдэлтэй байна	-	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ж.Ганхүлэг, Д.Одончимэг
	ДҮН	**25129.5**			

_____oOo_____